



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 1.2 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Оранжком ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх (яриа хот, хот хооронд-суурин) 14200016 тоот тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан хэрэглэгчийг өөр үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээнд шилжүүлэх ажлыг 60 хоногт багтаан зохион байгуулахыг Оранжком ХХК /Гүйцэтгэх захирал О.Мөнгөнсүх/-д, хэрэглэгч шилжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Зохицуулалтын газар /Г.Батболд/-т тус тус даалгасугай.
3. Оранжком ХХК-ийн хэрэглэгчийг өөр үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээнд шилжүүлэх хүртэлх хугацаанд харилцан холболтыг салгахгүй байхыг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдэд мэдэгдсүгэй.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР